



МОНГОЛ УЛСЫН  
ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧИЙН  
ЗАХИРАМЖ

2015 оны 05 сарын 29 өдөр

Дугаар 28

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.10, 14.2.3, Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоолд заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. “Улсын Дээд шүүхийн 2014 оны санхүүгийн аудитын тайланд өгөгдсөн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г хавсралтаар баталсугай.
2. Төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хэрэгжүүлэх, төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга Ж.Наранпүрэвт үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ



Ц.ЗОРИГ

050886



УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН 2014 ОНЫ САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАНД ӨГӨГДСӨН ЗӨВЛӨМЖИЙН ДАГУУ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Асуудал	ҮАГ-ын ажиглалт	ҮАГ-ын зөвлөмж	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хариуцах ажилтан
1. Урсгал зардлын зарцуулалт	Төсвийн тухай хуулийн 42.7-д “Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж тус тус заасанд нийцэхгүй байна.	Төсвийн тухай холбогдох заалтыг хэрэгжүүлэх, урсгал зардлаас хөрөнгө бэлтгэхгүй байх;	ҮАГ-аас өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх, батлагдсан төсвийн хүрээнд хөрөнгө бэлтгэхэд зохих зөвшөөрлийг холбогдох байгууллагуудаас авч ажиллах	Ж.Наранпүрэв Н.Булгамаа
2. Томилолтын зардал	Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, “Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоолын 5-д “гадаад албан томилолтын зардлыг бууруулах, зайлшгүй тохиолдолд зорчих төлөөлөгчийн тоог цөөлөх, төсвийн хөрөнгөөр бизнес ангилалын нислэгээр зорчихгүй байх” гэж тус тус заасанд нийцэхгүй байна.	“Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоолыг хэрэгжүүлж, зардлыг батлагдсан төсөвт багтаан зарцуулах;	ҮАГ-аас өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангахад анхаарч ажиллах	Ж.Наранпүрэв Н.Булгамаа